



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/149

Хэрлэн сум

Зүүн бүсийн нийтийн ахуй үйлчилгээний
анхдугаар зөвлөгөөн зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 8 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн бүсийн нийтийн ахуй үйлчилгээний салбарын тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөгжүүлэхийн тулд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах чиглэлээр зөвлөгөөн зохион байгуулахад 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Үнэнбат)-т, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



30 CO 2022

فصل ۹

بعض

پسندیدار

مصر و

Handwritten signature: *Handwritten signature*

مذہب .. یکم ص ۱۱

حسن مصطفیٰ

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 03-ний өдрийн
А/1149 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Заалны түрээс	12 цаг	250,000	3,000,000
2	Үдийн цай	200	20,000	4,000,000
НИЙТ ДҮН				7,000,000